

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан ЦЭХ-ийг найдвартай, үр ашигтай дамжуулах нь бидний эрхэм зорилго мөн.

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК



Тэрэл цацуулсан



“Мавин таван жил”



2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

№03 (153) 2022 оны 12 сар

МЭНДЧИЛГЭЭ



Эх орны хөгжил дэвшлийн тулгуур болсон Эрчим хүчний салбарын 100 жил, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 55 жилийн ойн мэндийг компанийн үе үеийн албан хаагчиддаа хамтатган дэвшүүлж, халуун талархал илэрхийлье.

Туурга тусгаар Монгол орноо цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлж 55 жилийн гэрэлт өдрийг бүтээлцсэн ахмад үеийнхэн болон тэдний түүчээ болж өнөөдрийн ачааг үүрэлцэж буй инженер техникийн ажилчидаараа бахархаж байгаагаа цохон тэмдэглэе.

Тэртээ 1967 онд Улаанбаатар хотын 3-р цахилгаан станцын 110 Кв-ын ил хуваарилах байгууламжийг Дархан хотын Дулааны Цахилгаан Станцтай 110 Кв-ын шугамаар холбож, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ үүсэх үндэс суурь тавигдсан. Тэр цагаас хойш өдгөө Улаанбаатар хот, 18 аймаг, 300 гаруй сум суурин, 1,24 сая км кв газрыг хамран, нийт хүн амын 72%-ийг цахилгаан эрчим хүчээр хангадаг үндэсний сүлжээ болон өргөжин тэлжээ. Хагас зуун жилийн түүхтэй дамжуулах сүлжээнийхэн өнөөдөр ололт амжилт бүхнээрээ бахархаж, хэтийн хөгжлийн зорилтоо тодорхойлж, хүндрэл бэрхшээлийг сөрж цахилгаан дамжуулах үүргээ тасралтгүй найдвартай гүйцэтгэж байна.

Монгол Улсын засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай, Сайншанд-Цагаансуварга, Багануур-Налайх-Улаанбаатар, Багануур-Чойр, Багануур-Чингис-Чойбалсан, Мандалговь-Арвайхээр, Тавантолгойн ДЦС-аас Оюутолгой хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 167 км урттай ЦДАШ татах, дэд станцын бүтээн байгуулалтын ажлууд бид бүхнийг хүлээж байна. Мөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлт багц асуудлын хүрээнд “Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангах” зорилт тусгагдсан. Тус төслийн хүрээнд дэлхийд томд тооцогдохуйц 80 МВт суурилагдсан хүчин чадалтай, 200 МВт цагийн багтаамж бүхий Литиум-Ион төрлийн батерей ашигласан хуримтлуурын байгууламжийг суурилуулж, 220/110/35 кВ-ын “Сонгино” дэд станцтай холбох өндөр хариуцлагатай ажилд хамтран зүтгэнэ.

Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийн салшгүй нэг хэсэг болсон “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хамт олон та бүхний ажилд амжилт хүсэж, салбартаа манлайлах тэргүүний байгууллага болохыг ерөөе.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАШДАВАА

НҮҮР-2

«ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН 55 ЖИЛ»
(ТҮҮХЭН ТОВЧООН)

НҮҮР-4

БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ

НҮҮР-5

ТӨВ УДИРДЛАГА

НҮҮР-6

УЛААНБААТАР САЛБАР

НҮҮР-8

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-9

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-10

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

НҮҮР-11

ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-12

2022 ОНЫ ЦДҮС ТӨХК-ИЙН
ШИЛДЭГ 10 АЖИЛ

ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН 55 ЖИЛ

Дамжуулах сүлжээний үүсэл. Монгол улсын их хурлаас эрчим хүчний салбарыг зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн Эрчим хүчний тухай хуулийг шинэчлэх баталснаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2001 оны 08 дугаар сард албан ёсоор байгуулагдсан. Тухайн үеийн төвийн эрчим хүчний системд байсан биеэ даасан цахилгаан шугам сүлжээний 4 газраас дамжуулах сүлжээнд хамаарах дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ)-ын өмчлөл, ашиглалт засварын үйл ажиллагааг хариуцаж ажиллах компани цоо шинээр байгуулагдсан юм.

Хэдийгээр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2001 онд байгуулагдсан боловч дамжуулах сүлжээ үүссэн он тооллыг авч үзвэл тэртээх 1967 он руу очих хэрэгтэй бөгөөд Дархан хотын Дулааны цахилгаан станцын хуваарилах байгууламжаас 110 кВ-ын ЦДАШ-аар Улаанбаатар хотын Дулааны цахилгаан станц-3 дахь ил хуваарилах байгууламжтай холбогдсоноор эх үүсвэрүүд болон хот хооронд цахилгаан дамжуулах сүлжээ албан ёсоор үүссэн юм. Энэхүү түүхэн өдөр бол 1967 оны 07 дугаар сарын 05-н бөгөөд тэр үеэс хойш дамжуулах сүлжээ 55 дахь жилийнхээ хөгжлийн түүхэн цаг үедээ ирээд байна. Он цагийн тоолол, өнгөрсөн цаг хугацааг дүгнэж үзэхэд Дамжуулах сүлжээ нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн салбарын хамгийн чухал том компани болж өргөжин тэлж, үнэ цэнэ, ач холбогдол нь өдрөөс өдөрт нэмэгдсээр байна.

Компанийн түүхэн товчоо

1967 он: Улаанбаатар хотын 3-р цахилгаан станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийг Дархан хотын Дулааны Цахилгаан станцтай 110 кВ-ын шугамаар холбож, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ үүсэх үндсэн суурь тавигджээ.

1968 он: 110 кВ-ын Зүүнхараа, Баруунхараа, Борнуур, Баянчандмань дэд станцууд ашиглалтад орсноор Төвийн эрчим хүчний систем байгуулагдав.

1970 он: 3-р цахилгаан станц ашиглалтад орсноор Дархан хотын Дулааны цахилгаан станцтай 110 кВ-ын 117 дугаар шугамаар, 2-р цахилгаан станцтай 35 кВ-ын Холбоо А,Б шугамаар тус тус холбогдож дамжуулах шугамын найдвартай ажиллагаа сайжрав.

1976 он: ОХУ-ын Галуут нуурын ГРЭС Дархан, Эрдэнэт хоттой 220 кВ-ын ЦДАШ-аар холбогдон Дархан 220/110/35, Эрдэнэт 220/110/35/6 кВ-ын дэд станцууд ашиглалтад орж, 220 кВ-ын 257, 258 дугаар шугамаар Дархан хот, 201, 202 дугаар шугамаар Эрдэнэт хот, 110 кВ-ын 117 дугаар шугамаар Улаанбаатар хот ОХУ-ын Сибирийн эрчим хүчний системтэй Монгол улсын эрчим хүчний систем холбогджээ.

1978 он: Улаанбаатар-Багануурын 220 кВ-ын ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станцыг ашиглалтад хүлээн авав.

1979-1980 он: Улаанбаатар хотод 110/35/10 кВ-ын Туул, 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцууд, 110 кВ-ын 105, 106 дугаар шугам баригдаж, Тойруу 110 кВ-ын шугамын эхлэлийг тавьжээ.

1981-1984 он: 4-р цахилгаан станц баригдаж ашиглалтад орсноор Улаанбаатар хот Дархан хоттой 208 дугаар шугамаар холбогдон системийн найдвартай ажиллагаа хангагджээ. Улаанбаатар хотын Тойруу 35 кВ-ын шугамыг 110 кВ-д шилжүүлж Баруун, Умард, Дорнод-2, Улаанхуаран, Амгалан 110 кВ-ын дэд станц ашиглалтад орж оруулж Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг дээшлүүлэв.

1986 он: 4-р цахилгаан станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламж Эрдэнэтийн 203, 204-р ЦДАШ ашиглалтад оров.

1989 он: Чойрт 220 кВ-ын дэд станцыг барьж, Багануураас 207 дугаар шугамаар холбож зүүн өмнөд бүсийн хэрэглэгчид Төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбогдов. Улаанхуаран дэд станцыг ашиглалтад оруулав.

1990-2000 он: Төвийн эрчим хүчний систем хүрээгээ тэлж өргөжин нийлбэр хүчин чадал 774 МВт хүрч Цахилгаан дамжуулах сүлжээ нь Улаанбаатар хот, Дархан хот, Эрдэнэт, Чойр, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгуудын нутаг дэвсгэрийг хамарсан хүрээтэй болов. “Эрчим хүчний хэмнэлт” төслөөр 220, 110, 35 кВ-ын 156 ширхэг гүйдлийн трансформатор, 121 ширхэг электрон тоолуур шинээр суурилуулжээ. Улаанбаатар-Налайхын 110 кВ-ын 101, 102-р ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2х25 мВа Налайх дэд станц, 110 кВ-ын Цэвэрлэх дэд станцууд тус тус ашиглалтад оров.

2001 он: УИХ-н 18-р тогтоолоор “Монгол улсын Эрчим Хүчний Тухай” хууль шинэчлэн баталснаар

Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор бүтцийн өөрчлөлт хийгдэж Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ төрийн өмчит хувьцаат компани байгуулагдав. Дэд бүтцийн сайдын 233-р тушаалын дагуу эзэмшлийн заагийг тодорхойлж, ил хуваарилах байгууламж-3, 4, Дарханы хаалттай хуваарилах байгууламж ЦДҮС ТӨХК-ийн эзэмшилд хүлээж авав.

2002 он: УИХ-н 23-р тогтоолоор Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр батлагдсанаар Төвийн эрчим хүчний нэгдсэн системийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд аж ахуйн харилцаанд орж нэг худалдан авагчийн загварт шилжив.

2003 он: Сайншанд-Замын-Үүдийн 110 кВ-ын 193,6 км ЦДАШ, 110/10 кВ-ын 1х10 мВА чадалтай Замын-Үүд дэд станц ашиглалтад оров.

2005 он: Арвайхээр-Баянтээг-Баянхонгорын 205 км 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 1х6,3 мВА чадалтай Баянтээг, 110/35/6 кВ-ын 1х6,3 мВА

чадалтай Баянхонгор дэд станц ашиглалтад оров. Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн хүрээнд Улаанбаатар хотын ДЦС-3, ДЦС-4-ийн ил хуваарилах байгууламжийн шинэчлэлээр 110 кВ-ын 27 ширхэг тосон таслуур, 81 ширхэг гүйдлийн трансформаторыг шинэчлэв. Мөн энэхүү төслөөр Улаанбаатар хот, Дарханы зарим 110 кВ-ын ЦДАШ-н аянгын троссыг OPGW маркийн шилэн кабель бүхий троссоор 220, 110 кВ-ын 8 дэд станцаас мэдээлэл хүлээн авах болон холбооны асуудлуудыг шийдвэрлэжээ.

2006 он: Шведийн Олон улсын хөгжлийн Агентлагийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах төсөл”-ийн зээлийн гэрээг Улсын их хурлын чуулганаар соёрхон батлав. ХБНГУ-н Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслөөр хяналт мэдээллийн СКАДА системийг нэвтрүүлэв.

2007 он: Улаанбаатар хотын 107-110-р ЦДАШ-ын үндсэн хамгаалалтын сигналыг шилэн кабелиар дамжуулж тойрог схемээр ажиллаж эхлэв. Умард, Баруун дэд станцуудад микропроцессорын реле хамгаалалтыг суурилуулав. Дамжуулах сүлжээний горимын тооцоог “Дакар” программаар хийдэг болов. 110/35/10 кВ-ын хүчдэлтэй, 1х1 мВА чадалтай Тосонцэнгэл дэд станц ашиглалтад оров.

2008 он: 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын хүчний трансформатор болон бусад бүх тоноглолыг бүрэн шинэчилж алсын удирдлагатай, НМІ бүхий анхны дэд станц болов. 110/10 кВ-ын Баруун дэд станцын хүчин чадлыг 2х25 мВА болгож нэмэгдүүлэв. Эрчим хүчний хөтөлбөр-1 төслөөр Дарханы 110 кВ-ын ХХБ-ийн тоноглолыг бүрэн шинэчлэв.

2009 он: 110/35/10 кВ-ын Хайлааст дэд станц, ЦДАШ-ыг ашиглалтад оруулав. ИХБ-4-д хоёр дахь 220/110/35 кВ-ын 125 000 кВА-ын автотрансформаторыг шинээр суурилуулав. 110/10/6 кВ-ын Умард дэд станцын тоноглолуудыг шинэчилж, хүчин чадлыг 2х40 мВА болгон нэмэгдүүлэв. Их чадлын трансформаторуудад засвар үйлчилгээ хийх засварын цехийг барив. “Эрчим хүчний хөтөлбөр-1” багц-1-ийн нэмэлт төслөөр 220, 110 кВ-ын 19 дэд станцын аккумуляторуудыг шулуутгагч, тогтмол гүйдлийн панелейн хамт иж бүрэн шинэчлэв. Улаанбаатар хотын хойд тойрог шугамын үндсэн хамгаалалтыг шилэн кабель ашиглан ажиллагаанд оруулан кольцо схемээр ажилладаг болгов.

2010 он: Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах төсөл хэрэгжиж дуусав. Төслийн хүрээнд 15 дэд станцад 220 кВ-ын 38 ширхэг, 110 кВ-ын 37 ширхэг, 35 кВ-ын 1 ширхэг элегаз таслуур, 220 кВ-ын 9 ширхэг, 110 кВ-ын 8 ширхэг гүйдлийн трансформатор, 35 кВ-

ын 10 мВар-ын 1 реактор шинээр суурилуулснаас гадна Улаанбаатар дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламжийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд тус ажил нь Эрчим хүчний салбарын 2010 оны шилдэг бүтээн байгуулалтын ажлаар шалгарчээ. 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын бүх тоноглолуудыг бүрэн шинэчилж, хүчин чадлыг 2х25 мВа болгон нэмэгдүүлсэн.



Туул дэд станц
трансформатор
хүчин чадлыг
нэмэгдүүлэв

Баянхонгор, Мөрөн дэд станцад хоёр дах трансформаторыг суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлэв.

2011 он: 110/10 кВ-ын Амгалан дэд станцын бүх тоноглолуудыг бүрэн шинэчилж, хүчин чадлыг 2х25 мВа болгон нэмэгдүүлэн алсын удирдлагатай болгох нөхцөлийг бүрдүүлэв. 110/35/10 кВ-ын Туул дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж 2х40 мВа болгов.

2012 он: Компани үйлчлэх хүрээ өргөжин тэлсэнтэй холбогдуулан албан ёсны нэрийг өөрчлөн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болгосон. 110/35/10 кВ-ын Тавантолгой, 110/35/10 кВ-ын Оюутолгой дэд станц, 217, 218-р ЦДАШ, Мөрөн-Тэлмэн-Улиастайн 110 кВ-ын ЦДАШ-ыг ашиглалтад оруулав. Оюутолгойн уурхайг ЦЭХ-ээр хангах БНХАУ-ын өвөр монголын эрчим хүчний системтэй холбогдсон 220 кВ-ын ЦДАШ, Төв дэд станц ашиглалтад оров.

2013 он: Налайх дүүрэгт 50 МВт Салхин парк ашиглалтад орж, 110/35/10 кВ-ын Налайх дэд станцтай холбогдов.

2014 он: Амгалан дулааны станцын 110/10 кВ-ын 2х16 мВа Дулаан дэд станц ашиглалтад оров.

2015 он: Улаанбаатар хотод их тойрог 110/220 кВ-ын сүлжээний Телевиз, Найрамдал, 7-р хороолол дэд станц, 135-138-р ЦДАШ ашиглалтад оров.

2016 он: Улаанбаатар хотод их тойрог 110/220 кВ-ын сүлжээний Зайсан, Дүнжингарав дэд станц, 125, 126-р ЦДАШ ашиглалтад оров.

2017 он: Баянчандмань дэд станцад өргөтгөл хийж, 2х12,5 мВа хүчний трансформатор суурилуулж, 110 кВ-ын транзит дэд станц болгов. “Полихлорт Бифенилийг байгаль орчинд ээлтэй аргаар устгах менежментийн чадавхыг бий болгох” төслийн хүрээнд DMU50.2000 24С маркийн төхөөрөмжөөр төслийн хугацаанд “ЦДҮС” ТӨХК нь 2012 оноос эхлэн 2017 оны 11 дүгээр сар хүртэл нийт 131 тоноглолын 1002 тонн ПХБ-ийн бохирдолтой цахилгаан тоног төхөөрөмжийг цэвэрлэн хоргүйжүүлж, төслийн үндсэн зорилтыг биелүүлсэн. ХБНГУ-аас эрчим хүчний салбарт олгох 20.45 сая еврогийн

хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалтыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК (ЦДҮС) дээр хэрэгжүүлэх “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг Сангийн яам, Эрчим хүчний яам, “ЦДҮС” ТӨХК болон KfW банкны хооронд энэ оны 6 дугаар сард байгуулсан.

2018 он: 110/35/10 кВ-ын Сайншанд дэд станцад өргөтгөл шинэчлэлт хийж, 110 кВ-ын бүх тоноглолыг шинэчлэв. “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Зээл болон төслийн гэрээ”, “Тусгай гэрээ”-г МУ-ын Засгийн Газар, ХБНГУ-ын Засгийн Газар, KfW банк, “ЦДҮС” ТӨХК-ийн хооронд энэ оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулав.

2019 он: Газрын тос боловсруулах үйлдвэрийг ЦЭХ-ээр хангах 110 кВ-ын Ширээт дэд станцыг ашиглалтад хүлээж авав. Уг ажил нь эрчим хүчний салбарын оны шилдэг бүтээн байгуулалтаар шалгарав. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулж, цахилгаан халаалтад шилжүүлэх 2х40 мВа Хүчит шонхор дэд станц ашиглалтад оров. Шахмал түлшний үйлдвэрийг ЦЭХ-ээр хангах Илчбаян дэд станц, 220/110/35 кВ-ын Мандал дэд станц тус тус ашиглалтад оров. Оюутолгой уурхайн зарим хэрэглээг 35 кВ-ын ЦДАШ-аар тэжээж эхлэв.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, МҮЭХ, МАОЭНХолбоо хамтран зарласан “Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2019” болзолт уралдааны дэд байр эзлэв.

2020 он: Улаанбаатар хотод Их тойрог 110/220 кВ-ын сүлжээ иж бүрнээр ашиглалтад оров. 220/110/35 кВ-ын Сонгино дэд станц, 110/35/10 кВ-ын Ташгай, 110/35/10 кВ-ын Арцат дэд

станц, 121, 122, 127, 128, 131, 132-р ЦДАШ-г хүчдэлд залгаснаар Улаанбаатар хотын их тойрог сүлжээ бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэв. Тавантолгой, Оюутолгой дэд станц 220 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжиж, 217, 218, 223, 224-р ЦДАШ ашиглалтад оров.

2021 он: 220 кВ-ын Цагаансуварга дэд станц, Оюутолгой-Цагаансуварга хоорондох 221, 222-р ЦДАШ ашиглалтад оров. Дэлхийн банкны төслийн хүрээнд Хангайн бүсийн салбарын 35 кВ-ын 10 ком тосон таслуурыг РХА-н хамт иж бүрнээр шинэчлэх ажил, Телевиз дэд станцыг алсын удирдлагатай болгов.

Эрдэнэт дэд станцын 2х200 мВа чадалтай автотрансформаторыг ЦДҮС ТӨХК-ийн инженерүүд өөрсдийн хүчээр иж бүрэн засварлав. “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн ЭХЯ, “ЦДҮС” ТӨХК болон төслийн хэрэгжилтэд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр шалгарсан ХБНГУ-ын Integration Umwelt&Energie компанийн хооронд “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-г 2021.12.01-ний өдөр байгуулав.

2022 он: Дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний 55 жилийн ой тохиож байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, МҮЭХ, МАОЭНХолбоо хамтран зарласан “Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2021” болзолт уралдааны тэргүүн байр эзлэв.



БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 55 жилийн ойд үе үеийн гүйцэтгэх захирлуудын төлөөлөл халуун сэтгэлийн мэндчилгээ илгээснийг “Дамжуулах сүлжээ” сонины уншигч, хамт олондоо уламжилж байна. Монгол улсын эрчим хүчний салбартай амьдралаа холбож, гэрлийн замналаар түүхээ бичсэн эрхэм инженерүүдийг алдаршуулан толилуулъя.



Н.НАМХАЙ-ТБЦДС ТӨХК-ийн анхны захирал,
Монгол улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан

Миний бие 1946 онд Ховд аймгийн Булган сумын нутагт төрсөн. 1965 онд төрөлх сумынхаа 10 жилийн дунд сургууль, 1972 онд Москва хотын Эрчим хүчний дээд сургуулийг магистр цолтой төгсөж улмаар, улмаар 1984 онд МАХН-ын дэргэдэх Намын дээд сургуулийг дүүргэж, нам-улс төрийн дээд боловсрол эзэмшсэн. 1972-2000 он хүртэл Улаанбаатар хотын цахилгаан шугам сүлжээний газарт инженер, ахлах инженер, салбарын дарга, үйлдвэр техникийн хэлтсийн дарга, борлуулалт эрхэлсэн орлогч дарга, ерөнхий инженер, орон тооны намын үүрийн дарга, 2001 оноос “ТБЦТС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал болон аймаг, хотын намын хороонд үйлдвэр үйлчилгээ эрхэлсэн хэлтсийн эрхэлэгч зэрэг албан хашсан билээ. Монгол улсын эрчим хүчний хөгжил дэвшилд мэдлэг боловсрол, дадлага туршлага бүхнээ зориулсаныг салбарын хамт олон, түүх гэрчилнэ. 2001 онд “ТБЦТС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын албанд томилогдсон нь миний хувьд түүхэн үйл явдал болсон юм. Хожим тус компани “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болон өргөжин тэлж, үүсэн байгуулагдсан 1967 оныг тодотгож өнөөдөр 55 жилийн ойгоо тэмдэглэж байна. Тус компанийн анхны захирал болж түүхэнд үлдэнэ гэдэг нэр төрийн хэрэг билээ. Ингээд эрчим хүчний салбарын хамт олон болон дамжуулах сүлжээний үе үеийн ажилтан, албан хаагчиддаа компанийн 55 жилийн ойн баярын мэндийг хүргэж ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.



Д.БАССАЙХАН-ТБЦДС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал асан,
Монгол улсын зөвлөх инженер

Монгол улсын эрчим хүчний салбарын 100 жил, цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ үүсч хөгжсөний 55 жилийн түүхт ойг тохиолдуулан цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанийн үе үеийн хамт олон та бүхэндээ ойн баярын мэндчилгээ дэвшүүлъя. Миний бие тус компанийн гүйцэтгэх захирлаар 2005-2010 онд ажиллах хугацаандаа дамжуулах сүлжээний техник, технологийн шинэчлэл хийж найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах, ажилтнуудын цалин, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дамжуулах сүлжээний үндсэн хөрөнгийг дахин үнэлж өртөг зардлыг нь тарифт тусгах замаар компанийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, импортын эрчим хүчийг төлөвлөсөн хэмжээнд барьж, тасралт саатал, дамжуулалтын алдагдлыг бууруулах зэрэг олон олон ажлын ард хамт олныхоо хүчээр гарч, салбарын найдвартай ажиллагаа, санхүүгийн чадавхид ахиц дэвшил гарсанд сэтгэл ихээхэн өөдрөг байдаг юм. Эдгээрээс томоохон зарим ажлуудыг дурьдвал, Шведийн засгийн газрын буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлсэн “Төвийн бүсийн дамжуулах шүлжээг шинэчлэн засварлах” төслийн хүрээнд 220 кВ-ын бүх дэд станц, 110кВ-ын гол чухал 9 дэд станцын тосон таслуур, хуурай салгуур, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг амжилттай хийж хэрэгжүүлсэн, дамжуулах шугамын утас, тулгуур, тусгаарлагч, трансформатор тоноглолуудын үндэсний стандарт болон байгууллагын стандартыг боловсруулж батлуулсан, компанийн үнэгүйдсэн үндсэн хөрөнгийг зах зээлийн үнээр дахин үнэлж их засвар, хөрөнгө оруулалтын шинэчлэл хийх хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж байсан, ажилагсадын цалинг хэд хэдэн удаа ойр ойрхон нэмэгдүүлж, ТБЦДС ТӨХК-ийн төв компани болон хөдөө орон нутагт ажиллаж байгаа салбарын ажилчдын цалингийн зөрүүг арилгаж, ээлжийн монтёруудыг ээлжийн инженер болгож цалин, зэрэглэлийг нэмэгдүүлсэн зэрэг хийж хэрэгжүүлсэн олон ажлуудаасаа дурдахад сайхан байна. Монгол улсад илч гэрлийг түгээх амин судас болсон Цахилгаан дамжуулах сүлжээ компанийн хамт олны ажил үйлс үеэс үед өөдлөн дэвшиж, Монгол Улсын гал голомт мандан бадрах болтугай.



Э.ТҮВШИНЧУЛУУН Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, Гүйцэтгэх захирал асан

Монгол улсынхаа хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж, эх орныхоо гал голомтыг бадрах ариун үйлсэд бие, сэтгэлээ дайчлан хүчин зүтгэж ирсэн “ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ХК-ний үе үеийн инженер техникийн ажилтан, ажилчид, албан хаагчид Та бүхэндээ Эрчим хүчний салбарын түүхт 100 жил, Цахилгаан дамжуулах сүлжээ үүсч хөгжсөний 55 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлъя.

Миний бие 2010 онд ТБЦДС ХК-ний гүйцэтгэх захирлаар томилогдсоноор дамжуулах сүлжээ компанийн өргөн мэдлэг, арвин туршлага, түшигтэй ахмадууд, орчин үеийн шинэ дэвшилтэт, техник технологийг эзэмшсэн, өндөр боловсрол, хийж бүтээх тэмүүлэл дүүрэн залуустай хамтран ажиллах боломж олдсон юм. Манай хамт олон зөвхөн ажил мэргэжилдээ шилдэг байгаад зогсохгүй авьяаслаг залуусаас бүрдсэн спортын баг маань 2012 онд Эрчим хүчний салбарын спортын наадамд анх удаа ТЭРГҮҮН байр эзэлж, ШИЛЖИН явах цомыг авсан зэрэг олон сайхан дурсамжуудыг бид хамтдаа бүтээсэн байна.

Аливаа хамт олны түүх, ололт амжилт бүхэн үе үеийн удирдлага, ажилтан, албан хаагчдын мэдлэг чадвар, сэтгэл зүтгэл, нөр их хөдөлмөрийн үр дүн байдаг.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ КОМПАНИ-аар овоглосон үе үеийн хамт олондоо аз жаргал, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Монгол орны гал голомт болсон эрчим хүчний салбар мандан бадрах болтугай.



Г.ЗАНДАНХҮҮ Монгол улсын зөвлөх инженер, Гүйцэтгэх захирал асан

Улс нийгэм, ард иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай, нэр төртэй биелүүлсээр ирсэн, цаашид ч эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд нэр төртэйгээр гүйцэтгэх итгэл төгс байгаа цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанийн нийт ажилчин, инженер техникийн ажилтан, албан хаагч Та бүхэндээ компанийхаа үүсэл хөгжлийн 55 жилийн ойн энэ өндөрлөгөөс чин сэтгэлийн талархал илэрхийлж амжилт бүтээлийн дээд, амьдралын сайн сайхныг хүсэн ерөөе.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХ Компани нь одоо Монгол Улсын нутаг дэвсгэрийн болон хүн амын 70 гаруй хувийг хамарч, нийслэл Улаанбаатар хот болон 16 аймаг, 300 гаруй сумын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангадаг үндэсний томоохон компани болон өргөжин хөгжжээ. Өндөр үүрэг хариуцлагаа ухамсарласан манай компанийн хамт олон хэрэглэгчээ дээдэлсэн цахилгаан эрчим хүчээр найдвартай, тасралтгүй дамжуулах үүргээ нэр төртэй биелүүлж, ололт амжилтаа улам бататган, өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлэхээр итгэл төгс ажиллаж байдаг Та бүхнээрээ бахархаж явдгаа уламжлахад таатай байна.

“Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна” гэсэн эрхэм зорилготой төв компанийн болон нийт салбарын хамт олонтойгоо гар сэтгэл нийлэн ажиллаж байсан он жилүүдээ санан дурсахад сайхан байдаг юмаа.

Монгол Улсын Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХ Компани үүсч хөгжсөний 55 жилийн ойн баярыг тохиолдуулан алдар хүндтэй ахмадууд, нийт ажилтан, ажилчид Та бүхэндээ болон Та бүхний найдвартай ар тал болсон гэр бүлийнхэнд чин сэтгэлийн баяр хүргэе.

ТӨВ УДИРДЛАГА



Хэлтсийн дарга П.Аюушибилэг, Б.Цацрал, Г.Алтангэрэл,
Б.Солонго, Д.Шүрмаа, Г.Үрэлмаа, Д.Энхбаяр,
Д.Гэрэлмаа, Л.Энхжаргал, Б.Энхсанаа нар



Хэлтсийн дарга Д.Чинбат, Ш.Мөнхжаргал,
Б.Пүрэвхүү, Б.Гантөгс, П.Ариунболд, П.Баярсүрэн,
С.Мөнхцэцэг, Б.Энхбат, Б.Цэцэгмаа, Х.Баянмөнх,
А.Ананд, Д.Доржпүрэв, Б.Амарбаясгалан нар



Хэлтсийн дарга М.Өмөрбай, ахлах инженер
Ж.Чинзаяа, М.Сэржхорол, Х.Лхагвасүрэн,
Л.Ариунболд, Ч.Бат-Эрдэнэ, Б.Ариунболд,
П.Пүрэвсүрэн, С.Сэд-Аюуш, Б.Батжаргал, Г.Хангай



Хэлтсийн дарга Я.Мөнхтөр, ахлах инженер
Д.Мөнхзаяа, Б.Батчулуун, Н.Эрдэнэжаргал,
Б.Болормаа, Б.Баярлах, биеийн тамирын зааварчлагч
Ц.Цэцэнпүрэв, хүний их эмч Э.Ууганцэцэг,
О.Уранцэцэг нар



У.Байгальмаа, Б.Энхмаа, Л.Төмөрсүх,
Ш.Уранчимэг, Б.Ганццэг, Э.Түмэнжаргал,
З.Мөнхнасан, Э.Бадамцэцэг, Э.Болор-Эрдэнэ,
Г.Тунгалагтамир, О.Долгорсүрэн, Р.Отгонцэцэг нар



Хэлтсийн дарга Э.Бат-Орших, Л.Содовсүрэн,
Ч.Одбаяр, Э.Батбаяр, Д.Баттулга, Б.Галбадрах,
Б.Жаргалсайхан, Б.Энхзаяа, Н.Санзбуян, С.Болормаа,
Б.Сэргэлэнбаяр, Б.Дүмбэн-Ойдов, Н.Мэнд-Амар,
Б.Мэнд-Амар, Ө.Бямбадорж



Хэлтсийн дарга Ч.Нэргүй, Д.Нандинбилэг,
Ц.Баянмөнх, Б.Гантулга, Н.Барсболд, Ш.Аюурзана,
Б.Баярмаа, Э.Болормаа, Ш.Батболд



Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн
хамт олон



Хэлтсийн дарга Н.Батбаяр, ахлах инженер
З.Батзориг, Б.Золбоо, Б.Лут-Эрдэнэ, М.Ганзориг,
Ж.Хосбаяр, Д.Ганзул, Т.Нямдорж, Б.Баярхүү нар



А.Чинбат, Л.Эрдэнэбилэг, Н.Бодьгэрэл,
П.Зэрэгбаяр, Ц.Сайнтөгс, Д.Ариунболд нар



Т.Цэвэгсүрэн, Б.Батзориг, Н.Алтанбаатар,
Б.Жавхлантөгс, М.Батзориг, Б.Саруулбаяр,
Л.Ариунжаргал, Ц.Батбаяр нар

УЛААНБААТАР САЛБАР


МЭНДЧИЛГЭЭ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төхк-ийн
Улаанбаатар салбарын дарга Д.БУДХҮҮ

Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн ахмад ажилтнууд, дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг дээшлүүлж, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлж яваа компанийн хамт олон та бүхэндээ Монгол Улсад эрчим хүчний салбар үүсч хөгжсөний түүхт 100, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 55, Улаанбаатар салбарын 10 жилийн ой болон шинэ оны баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Эрчим хүчний салбартай ажил амьдралаа холбон хоёргүй сэтгэлээр зүтгэж байгаа компани болон салбарын хамт олон, мэргэжил нэгт нөхөддөө түүхт ойн баярын мэнд хүргэж, аз жаргал, эрүүл энх, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.


ЦДҮС ТӨХК-ийн УЛААНБААТАР САЛБАРЫН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ



110 кВ-ын ЦДАШ-аас тэжээгддэг гадны байгууллагын дэд станц
110/35 кВ-ын Салхит дэд станц
110/35/6 кВ-ын Суруга дэд станц
110/10 кВ-ын Баянгал дэд станц
110/35/10 кВ-ын Бөхөг дэд станц
35/10 кВ-ын Моннаран дэд станц

Байгуулагдсан он: 2012
Дэд станц: 34
Ажилтны тоо: 418
Хамрах хүрээ:
Баянзүрх дүүрэг
Баянгол дүүрэг
Хан-Уул дүүрэг
Чингэлтэй дүүрэг
Сүхбаатар дүүрэг
Сонгинохайрхан дүүрэг
Налайх дүүрэг
Багахангай дүүрэг
Төв аймгийн Баянчандмань сум

Хэрэглэгч: 461925
Суурилагдсан хүчин чадал: 2 445 000 кВА
Цахилгаан дамжуулах агаарын шугам:
Цахилгаан дамжуулах агаарын шугам:
220 кВ-ын шугамын трассын урт 409,6 км
Нэг хэлхээнд шилжүүлсэн урт 737,4 км
110 кВ-ын шугамын трассын урт 479,05 км
Нэг хэлхээнд шилжүүлсэн урт 778,8 км
35 кВ-ын шугамын трассын урт 7,5 км
Нэг хэлхээнд шилжүүлсэн урт 11,7 км
Нэг хэлхээнд шилжүүлсэн нийт урт 1527,9 км



Захиргаа, аж ахуйн алба



Реле хамгаалалт, хэмжилт туршилтын алба



Засварын алба



Санхүү, эдийн засгийн алба



ХАБЭА



Инженерийн хэсэг


УЛААНБААТАР САЛБАР



Амгалан дэд станц



Арцат дэд станц



Багахангай дэд станц



Баруун дэд станц



Баянчандмань дэд станц



Буянт-Ухаа дэд станц



Гео дэд станц



Дарь Эх дэд станц



Дорнод дэд станц



Дулаан дэд станц



Дундгол дэд станц



Дүнжингарав дэд станц



Зайсан дэд станц



Илч баян дэд станц



ИТА



ИХБ-3



ИХБ-4



Найрамдал дэд станц



Налайх дэд станц



Өмнөд дэд станц



Сэлбэ дэд станц



Ташгай дэд станц



Телевиз дэд станц



Толгойт дэд станц



Туул дэд станц



Улаанбаатар дэд станц



Улаанхуаран дэд станц



Умард дэд станц



Хөшигт дэд станц



Хүхрээ дэд станц



Цэвэрлэх дэд станц



Шонхор дэд станц



Яармаг дэд станц

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

МЭНДЧИЛГЭЭ

Хангайн бүсийн салбарын дарга Б.ГАНТУЛГА

Монгол улсын гал голомт болсон эрчим хүчний салбарын үе үеийн ахмадууд, инженер техникийн ажилтан, ажиллагсад та бүхэндээ Монгол улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани үүсэн байгуулагдсаны түүхт 55 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.


ТАНИЛЦУУЛГА

Анх 1974 онд Эрдэнэт үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор Сэлэнгэ аймгийн Орхон сумаас Орхон-Эрдэнэтийн 220 кВ-ын шугам баригдаж, Эрдэнэт хотод 110/6 кВ-ын 2 х 6300 кВА-гийн түр дэд станц ашиглалтанд орсноор манай байгууллагын суурь тавигдсан. 1978 онд Орхон-Дарханы 220кВ-ын 2 хэлхээт шугам, 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станц ашиглалтанд орж бүрэн схемээр ажиллаж эхэлсэн. Сайд нарын зөвлөлийн 1980 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 377-р тогтоолоор Эрдэнэт-Булганы ЦШС-ний газар байгуулагдсан. 2001 онд батлагдсан “Эрчим хүчний тухай хууль”-ийн дагуу эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийгдэж ЦШС-ний газрууд цахилгаан дамжуулах сүлжээ, цахилгаан түгээх сүлжээ болон хуваагдсанаар, Засгийн газрын 2001 оны 07-р сарын 09-ний өдрийн 164-р тогтоол, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн захирлын 2001 оны 08-р сарын 16-ны өдрийн 07 тоот тушаалаар ТБЦДС ТӨХК-ийн Эрдэнэт-Хархорины салбар нэртэйгээр 2001 оны 08-р сарын 01-ний өдөр шинэчлэн байгуулагдсан. Монгол улсын засгийн газрын 2012 оны 108 дугаар тогтоолоор компанийн нэр өөрчлөгдөж, 2012 оны 06-р сарын 26-ны өдрөөс эхлэн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн “ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР” нэртэй болж 5 алба, 2 хэсгийн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Манай салбар 220 кВ-ын Дархан-Эрдэнэтийн 201, 202, Улаанбаатар-Эрдэнэтийн

203, 204-р цахилгаан дамжуулах агаарын шугамаар 220/110/35/6 кВ-ын Дархан дэд станц болон Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц, 110 кВ-ын 151, 152-р шугамаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Дулааны цахилгаан станцтай, 110 кВ-ын 153-р шугам, 35 кВ-ын Блок-1,2,3-р шугамаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станцтай тус тус холбогддог.

Нэг хэлхээнд шилжүүлсэнээр 220кВ-н шугам 417,6 км, 110кВ-н шугам 1639,3 км, 35кВ-н шугам 7,91 км, 220/110/35/6 кВ-ын 1 дэд станц, 110/35/10 кВ-ын 8 дэд станц, 110/35/6 кВ-ын 2 дэд станц, 110/10 кВ-ын 1 дэд станцтай, Орхон, Булган, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Төв, Дундговь, Сэлэнгэ, Завхан, Өмнөговь, Говь-Алтай зэрэг 12 аймгийн 150 гаруй сум суурин газрын хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг тасралтгүй найдвартай дамжуулж байна.

Салбарын ЦЭХ-ний нийт дамжуулалтын 65 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ ба Орхон аймгийн хэрэглэгчид, 35 хувийг бусад аймгуудын төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдсон хэрэглэгчид авдаг бөгөөд жилдээ 1 тэрбум 587 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг найдвартай дамжуулж үндсэн үүргээ амжилттай биелүүлж байна. Тус салбар нь 94362,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 213,3 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй.



Эрдэнэт



Хархорины хэсэг



Санхүү, эдийн засгийн алба



Реле хамгаалалт, хэмжилт туршилтын алба



Булган дэд станц



Цэцэрлэг дэд станц



Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба



Захиргаа, аж ахуйн алба



Арвайхээр дэд станц



Засварын алба

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

МЭНДЧИЛГЭЭ

Төвийн бүсийн салбарын дарга Ж.МӨНХЖАРГАЛ

Монгол улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн баярын мэндийг эрчим хүчний салбарын үе үеийн ажиллагсад болон ЦДҮС ТӨХК-ийн хамт олондоо өргөн дэвшүүлье. Салбарын тэгш ойттой зэрэгцэн компанийн 55 жилийн ой тохиож байгаа энэ цагт бид бүхэн бүтээсэн түүхээрээ бахархаж, ирээдүйгээ итгэл төгс харж, ажил хөдөлмөртөө хоёргүй сэтгэлээр зүтгэж байна. Та бүхний ажил, амьдралд сайн сайхныг хүсэн ерөөе.



ТАНИЛЦУУЛГА

Төвийн бүсийн салбар нь 1965 онд БНМАУ-н Сайд нарын зөвлөлийн 155-р тогтоолоор “Дархан Сэлэнгийн Цахилгаан Шугам Сүлжээний Газар” нэртэйгээр анх байгуулагдсан ууган салбар юм.

2001 онд Монгол Улсын Засгийн Газрын 164-р тогтоолоор эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудад бүтцийн өөрчлөлт хийгдэж тус салбар нь “Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ” ТӨХК-ийн харьяа Дархан-Сэлэнгийн салбар нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

2012 онд Монгол Улсын Засгийн газрын 108 тоот тогтоолоор тус компанийг “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК болгон өөрчилж Төвийн бүсийн салбар нэртэй болсон.

Сурилагдсан хүчин чадал

Төвийн Бүсийн Салбар нь 220, 110кВ-ын 18 дэд станцтай бөгөөд нийт 452,8 МВт суурилагдсан хүчин чадалтай. Мөн ОХУ – аас 245МВт чадлыг Дархан дэд станцаар дамжуулан төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбогдсон.

2019 онд суурилагдсан чадлыг 27 МВт-р нэмэгдүүлж 452,8 МВт болсон ба өнөөдрийн байдлаар 28% ачаалалтай ажиллаж байна

Салбарын схемийн онцлог

ОХУ болон МУ-ын ЭХС – ийг холбосон СД-257, 258 АШ мөн ДЦС-4 –тэй холбогдсон УБ-208 АШ, Эрдэнэтийн Уулын баяжуулах үйлдвэрийн үндсэн тэжээл ЭТ-201, 202 АШ –ыг хариуцдаг. 110кВ талдаа ДДЦС-ДЦС-4-ийг холбосон транзит 113, 114, 115, 116, 117-р АШ-тай ба Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн сум суурин газрыг хамарсан эрчим хүчний системийн төвийн бүсийг хариуцсан схемтэй анхдагч салбар юм.


Дэд станцын тоо, ЦДАШ-ын нийт урт

Манай салбар нь 18 дэд станц, 220кВ-ын 5 шугам, 110кВ-ын 12 шугамтай. Үүнд : Дэд станц

220/110/35 кВ-ын дэд станц	1
110 кВ-ын ХХБ	1

110/6 кВ-ын дэд станц	5
110/10 кВ-ын дэд станц	2
110/35/6кВ-ын дэд станц	5
110/35/10кВ-ын дэд станц	4
Шугам тоноглол	
220 кВ-ын 5 шугам нийт 310.86 км	
1 хэлхээтэй 121.4 км	
2 хэлхээтэй 189.46 км	
Нэг хэлхээнд шилжүүлсэн нийт урт 494.32 км	
110 кВ-ын 12 шугам нийт 677.55 км	
1 хэлхээтэй 613.31км, 2 хэлхээтэй 63.74км	
Нэг хэлхээнд шилжүүлсэн нийт урт 740.79км	

“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн Бүсийн Салбар нь Дархан-Уул, Сэлэнгэ аймаг бүхэлдээ, Төв аймгийн хойд чиглэлийн 7 сум нийтдээ 40 орчим сум, төв суурин газрын хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг дамжуулах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүний дотор Дарханы Хар төмөрлөгийн үйлдвэр, Хөтөлийн Цемент шохой үйлдвэр, Эрдэнэтийн Уулын баяжуулах үйлдвэр, Эрэл ЦШҮ, Болд төмөр-Ерөө гол зэрэг МУ-ын эдийн засагт чухал ач холбогдолтой томоохон үйлдвэрүүдийг ЦЭХ-ээр хангаж байна.



Санхүү, эдийн засгийн алба

Инженерийн хэсэг



Реле хамгаалалт, хэмжилт туршилтын алба



Засварын алба



Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба



Захиргаа, аж ахуйн алба



Зүүнхараа дэд станц



Дархан дэд станц

Байгуулагдсан он	1965
Дэд станц	18
Ажилтаны тоо	210
Удирдлага	5
ЗААА	24
РХАХТА	13
Инженерийн хэсэг	7
АШҮА	130
Засварын алба	24
ЭЗС-ын алба	7
Суурилагдсан хүчин чадал	452,8 мВА
Нийт ЦДАШ-ын урт	1230 км
Хамрах хүрээ /сум суурин газар/	28
айл өрх	46288
ААН	5461

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР



МЭНДЧИЛГЭЭ

Зүүн-Өмнөд бүсийн дарга П.ГАНБАЯР

Монгол улсад Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ой, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК байгуулагдсаны 55 жилийн ойн баярын мэндийг Монгол улсын өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч байгаа Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК ийн хамт олондоо хүргэе!

Компани, салбартаа олон жил өөрийн хүч хөдөлмөр, авъяас билэг, оюун ухаанаа зориулан ажиллаж байсан ахмадууддаа, одоо ажиллаж байгаа ажилтнууддаа баярын мэндийг дахин хүргэж ажил хөдөлмөрт нь өндөрөөс өндөр амжилтыг хүсэж, өргөө гэр тань гэрлээр дүүрэн, өрх бүр аз жаргалаар дүүрэн байхын ерөөлийг өргөө!

ТАНИЛЦУУЛГА

Манай салбар нь анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 328 тоот тогтоолоор “БАГАНУУР ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР” нэртэйгээр байгуулагдсан.


2012 онд Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ ТӨХК-ийг Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК, тус салбарыг Зүүн-Өмнөд бүсийн салбар нэртэй болгон өөрчилсөн.

Үйлчлэх хүрээ

ЦДҮС ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбар нь Нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэрт байгаа 80 гаруй сум суурин газар, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, МАК, Монполиментийн цементийн үйлдвэр, Монгол-Оросын хамтарсан Улаанбаатар төмөр зам ХНН-ийн Эрчим хүч, ус хангамжийн 1, 2-р ангиуд зэрэг 2098 үйлдвэр аж ахуйн нэгж, 42000 орчим айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Суурилагдсан хүчин чадал

Манай салбар нь 729.2 МВА суурилагдсан хүчин чадалтайгаар нийтдээ 220/110 кВ-ын 1051,1 км шугам, 220 кВ-ын 2 дэд станц, 110 кВ-ын 10 дэд станцын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг.



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

МЭНДЧИЛГЭЭ

Говийн бүсийн салбарын дарга Н.БЯМБАДОРЖ

Эх орондоо илч гэрэл түгээх үйлсээ нэр төртэй биелүүлж буй Говийн бүсийн салбарын хамт олон болон компанийн нийт инженер техникийн ажилтан, ажиллагсад, ахмадууд та бүхэндээ Монгол улсад эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жил, Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК үүсгэн байгуулагдсаны 55 жилийн түүхт ойн мэндийг хүргэхийн зэрэгцээ айлчлан ирж буй 2023 оны Шинэ жилийн баярын мэнд дэвшүүлье.

Монгол орны өмнөд бүсийн уул уурхайн стратегийн орд газруудыг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах чиглэлээр салбарын харьяа дэд станцуудад өмнөх онуудад өргөтгөл шинэчлэлийн ажлууд хийж ирлээ. Үүнийг дагаад салбарын үйлчлэх хүрээ тэлж, үзлэг, засвар үйлчилгээ хийх шугам, тоноглол нэмэгдэхийн хэрээр байгууллагын үнэт зүйл болсон ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, сургаж дадлагажуулах, чадваржуулах хүндтэй үүрэг оногдож байна.

Өрнөл хөгжлийн түүчээ, илч гэрлийн эзэд болсон нийт хамт олондоо ирж буй ондоо ажил үйлс нь өөдөө байж амжилт бүтээл нь арвин байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

ТАНИЛЦУУЛГА



Санхүү, эдийн засгийн алба



Реле хамгаалалт, хэмжилт туршилтын алба



Засварын алба



Мандал дэд станц



Тавантолгой дэд станц



Оюутолгой дэд станц



Цагаан суварга дэд станц



Даланзадгад дэд станц

2022 ОНЫ ЦДҮС ТӨХК-ИЙН ШИЛДЭГ 10 АЖИЛ

№	Гүйцэтгэсэн ажил	Хариуцсан хэлтэс, салбар
1	Дархан дэд станцын 220 кВ-ын 63 МВА чадалтай АТ-1 трансформаторын бүрэн хэмжээний задаргаат их засварын ажлыг компанийн дотоод нөөц бололцоо, боловсон хүчинд тулгуурлан анх удаа бие даан хийж гүйцэтгэлээ.	ТХХ ТБС
2	110/35/10 кВ-ын Дарь-Эх дэд станцын 35 кВ талын ачааллыг хөнгөлөх зорилгоор 35 кВ-ын Яргайт-А,Б АШ-ын трассыг өөрчлөн ачааллыг Сэлбэ дэд станцад шилжүүлэх ажлын техникийн шийдлийг гаргаж амжилттай зохион байгуулсан.	ТБТХ УБС
3	110 кВ-ын Өндөрхаан агаарын шугамын 12 км утас солиж, ЦДАШ-ын ашиглалтын түвшинг дээшлүүллээ.	ТБТХ ЗӨБС
4	Сонгино, Мандал дэд станцуудыг холбосон 213,214-р АШ-уудад ОАПВ-г оруулж өгснөөр системийн хэмжээнд тасралт саатал, савлалтын үед найдвартай ажиллагааг хангаж ажиллах нөхцөл бүрдсэн.	РХАХТХ ГБС, УБС
5	ИХБ-4, ИХБ-3, Улаанбаатар, Дорнод-2, Туул, Хүрхрээ, Налайх дэд станцуудын бүх РХА-н төхөөрөмжүүдийг нэг синхрон цагийн системд холбосноор тасралт саатал болон аваргийн үеийн бичлэг авч, дүгнэлт гаргахад цагууд хоорондоо зөрөхгүй, РХА-н төхөөрөмжүүдийн хооронд параметруудийн мэдээлэл нэгэн зэрэг солилцох давуу тал үүссэн. Цаашид хяналт удирдлагын ерөнхий систем бүрдүүлсэн үр дүнтэй ажил болсон.	РХАХТХ УБС
6	Монгол улсын экспортын чиглэлийн төмөр замын томоохон бүтээн байгуулалт болох Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд 220/110/35 кВ-ын Тавантолгой дэд станцын 35 кВ-ын хуваарилах байгууламжийг 2 ячеикээр өргөтгөх, 220/22/35 кВ-ын Цагаансуварга дэд станцын 22 кВ-ын хуваарилах байгууламжийг 2 ячеикээр өргөтгөх, 22/35 кВ-ын 2х1,6 мВА хүчний трансформатор, 35 кВ-ын 8 ячеик бүхий хаалттай хуваарилах байгууламжийг барьж ашиглалтад орууллаа.	ТБТХ ШЗХ ЗӨБС ГБС
7	35 кВ-н Гурвансайхан, Төв, 35 кВ-н Луус, Олгойнговь АШ-уудыг 220/110/35 кВ-н Мандал дэд станцад шилжүүлэх ажил бүрэн хийгдлээ. Мөн 35 кВ-н Төв АШ-ын шилэн кабель бүхий аянтын троссны холболт хийгдэж, төв оффис болон Мандал дэд станцыг холбосон интернэтийн урсгалын тасралтгүй найдвартай ажиллагааг хангасан.	МТХ ГБС
8	Төвийн бүсийн салбарын төв оффис дээр сервер бүхий алсын удирдлагын хяналт мэдээллийн программыг ажиллагаанд оруулж салбарын хэмжээнд дэд станцуудыг алсаас удирдах хянах систем нэвтрүүлсэн.	РХАХТХ ТБС
9	110 кВ-ын Хархорин АШ-д шувуу үргэгч суурилуулах, аэродинамик тусгаарлагчаар солих ажлуудыг хийж гүйцэтгэж шугам тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.	ТБТХ ХБС
10	Түлш эрчим хүчний улсын албаны гамшгийн үед ашиглах тоон системийн радио холбоог Улаанбаатар хотын орчимд ашиглах зориулалттайгаар шинээр суурилуулж, холбох ажлыг гүйцэтгэсэн. Тус холбоог ЭХЯ, УБЦТС ТӨХК, ЦДҮС ТӨХК компаниуд одоогийн байдлаар ашиглаж байна. Мөн компанийн Улаанбаатар салбарын 16 дэд станцын шуурхай ажиллагааны холбоонд ашиглаж байна.	МТХ

Үг: У.Баяндорж

Ая: Б.Бямбабаяр

ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ

Амгалан орших Монголынхоо хөгжлийг
Алхаж мөрлөх хөгжлийн хэлхээ
Алтран мандах наран ээлээр
Ард түмнийхээ мэлмийг гийгүүлнэ /Эрчмийнхэн/

ДХ: Амилахуй тэнгэр наран хэмтэй
Алганы хээ шиг амин хэлхээ
Гийгүүлэх нарны илчийг түгээнэ
Гэрлийн урсгалаар амьдрал тэтгэнэ /Дамжуулах сүлжээ/

Эрдмийн цогоор асааж гэрэлтдэг
Эрчим түмний өглөг гүйдлийг
Зэллэх гангийн жингэнэх уянгаар
Зэрэглэх цамхгийг өртөөлж түгээнэ /Эрчмийнхэн/

ДХ: Амилахуй тэнгэр наран хэмтэй
Алганы хээ шиг амин хэлхээ
Гийгүүлэх нарны илчийг түгээнэ
Гэрлийн урсгалаар амьдрал тэтгэнэ /Дамжуулах сүлжээ/

Дэлхийн нартай энсэж гэрэлтүүлнэ
Дээжис түүхээ хайрлаж амьдруулна
Урагшаа хөгжлийн эрчийг тэтгэнэ
Ухаант дээдсийн голомтыг дээдэлнэ /Эрчмийнхэн/

ДХ: Амилахуй тэнгэр наран хэмтэй
Алганы хээ шиг амин хэлхээ
Гийгүүлэх нарны илчийг түгээнэ
Гэрлийн урсгалаар амьдрал тэтгэнэ /Дамжуулах сүлжээ/

